



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2021 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 1/175

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн "Сумын 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг дээшлүүлэх, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг сайжруулах" хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын хэрэгжилтэнд магадлах аудит хийлгэх санхүүжилт 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын хэрэгжилтэнд магадлах аудит хийлгэх санхүүжилтэд зарцуулагдах 1500000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (М.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ